

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны дүгээр
сарын ...-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Булган мээж” ОНӨХХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/301 дугаар албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Булган аймгийн Булган сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Төсөвт байгууллагын батлагдсан тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага болон орон сууцны айл өрхийн тарифыг 2025 оны 05 дугаар 16-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Булган-Мээж” ОНӨХХК (Г.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 459 дүгээр тогтоолын хавсралтын 1 дэх хэсгийн 1,2,5 дугаар мөрөнд заасан Төсөвт байгууллагын тарифыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс, 3-7 дугаар мөрөнд заасан Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага болон орон сууцны айл өрхийн тарифыг 2025 оны 05 дугаар 16-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэ тарифын газар (Б.Эрдэнэбулган)-т даалгасугай.

ГАРЫН ҮСЭГ

**БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ
ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФ**

1. Булган аймгийн Булган сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал	Хэмжих нэгж	Тариф /НӨАТ-гүй/
1	Төсөвт байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	3,900.0
2	Төсөвт байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/ГЖ 68,937.6
		тогтмол	Төг/м ³ 497.1
3	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын эзлэхүүнээр тооцох халаалт	Төг/м ³	2,600.0
4	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	хувьсах	Төг/ГЖ 32,605.6
		тогтмол	Төг/м ³ 235.1
5	Төсөв, үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/м ³	4,500.0
6	Орон сууцны халаалт (оюутны байр, подвал, "0"-ын өрөөний халаалт хамаарна)	Төг/м ²	1,400.0
7	Ахуйн хэрэгцээний халуун ус халаасан дулаан	Төг/м ³	3,500.0